



1990 оны 12 дугаар  
сарын 25-ны өдөр

Дугаар 56

Улаанбаатар  
хот

КОМИСС БАЙГУУЛАХ ТУХАЙ

1. Гуч, дөчөөд он, тавиад оны эхэн үед улс төрийн хилс хэрэгт татагдаж хэлмэгдсэн хүмүүсийн асуудлыг үргэлжлүүлэн судалж цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах Улсын комиссыг дор дурдсан албан тушаалтны бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Комиссын дарга

-БНМАУ-ын Дэд ерөнхийлөгч

Орлогч дарга

-БНМАУ-ын Засгийн газрын хэрэг эрхлэх газрын дарга

Гишгүүд

-БНМАУ-ын Бага хурлын нарийн бичгийн дарга

-БНМАУ-ын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга

-БНМАУ-ын Сангийн сайд

-БНМАУ-ын Засгийн газрын дэргэдэх Улсын аюулгүй байдлыг хангах ерөнхий газрын дарга

-Комиссын нарийн бичгийн дарга

2. Комисст даалгах нь:

а/Улс төрийн хилс хэрэгт татагдаж "Онцгой бүрэн эрхт комисс", "Тусгай комисс" зэрэг шүүхийн биш байгууллагаар шийтгэгдсэн хүмүүсийн хэрэг, түүнд холбогдогсдыг нэрсийнх нь дагуу, шүүхээр шийтгэгдсэн бусад хүний хэргийг өргөдөл гомдлын үндсэн дээр шалгаж шийдвэрлэх, цагаатсан хүн, түүний гэр бүлийнхэнд тэтгэвэр, тэтгэмж олгох, хэлмэгдэгсдийн талаар судалж түүхэн үнэнийг тогтоох, нэр төрийг сэргээх ажилд холбогдох байгууллага, хүмүүсийг өргөн оролцуулж ажиллах;

б/Улс төрийн хэрэгт хилс шийтгэгдэгсдийг цагаатгах журамд зарим нэмэлт өөрчлөлт оруулах асуудлыг судлан шийдвэрлэх.

Бүгд Найрамдах Монгол Ард  
Улсын Ерөнхийлөгч

П.ОЧИРБАТ

Хуулбар үнэн. Тамгын газрын  
ахлах референт

Р.ТҮНЖИН